

**“Хай Би Ойл” ХК-ийн 2014 оны  
үйл ажиллагааны тайлан**

Нэр: “Хай Би Ойл” ХК

Хаяг: Улаанбаатар хот, СХД, 20-р хороо, Сонсголонгийн /18135/ 110 тоот

Утас: 99098989, 99095728

|                            |  |
|----------------------------|--|
| Улсын бүртгэлийн мэдээлэл: | № 9010001063,                                      |
| Регистрын дугаар           | № 2615134  |
| Үйл ажиллагааны чиглэл:    | Техникийн тосны үйлдвэрлэл, гадаад дотоод худалдаа |
| Хувьцаа эзэмшигчдийн тоо:  | 311 /2015.03.20-ны байдлаар/                       |

2014 онд хийгдсэн ажил үйлчилгээ:

- Бид эрчим хүч бага зарцуулах, богино хугацаанд тосоо сэлгэн халаах чадвартай уур үүсгэгч төхөөрөмж захиалж 2014 оны 1, 2 дугаар саруудад захиалгын дагуу угсралт, суурилуулалтыг хийлгэсэн. Үүнд уур үүсгэгчийн тенг болон гэр труба, тэжээлийн кабель, уурын трубаны трасс, шугам хоолойг шинэчилсэн байгаа. Үүний үр дүнд V-MAT-ийн уур үүсгэгчийн бохир тос халаах явц удаан байсныг 2-3 дахин түргэтгэсний зэрэгцээ цахилгаан эрчим хүчийг 2 дахин хэмнэх болсон.
- Үйлдвэрийг гэнэтийн гал түймэр болон хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор үйлдвэрийн орчныг камержуулж, дохиололжуулсан. Үйлдвэрийн ажилчдын ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлэхийн тулд зөөврийн оффис болон ажилчдын байрыг бариулж, ажилчдын ирэх буцах тээврийн асуудлыг бүрэн шийдвэрлэсэн.
- 2014 онд үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу тосны үйлдвэрлэлийг хэвийн ажиллуулах зорилгоор үйлдвэрт ашиглагдаж байгаа бохир болон боловсруулсан тос нөөцлөх сав, агуулах дутмаг байсан ба нэмж үйлдвэрийн агуулахын хүчин чадлыг 150 тонноор нэмэгдүүлсэн. Үүнийг угсрах суурилуулах ажлыг 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж тус онд багтаан хийж гүйцэтгэнэ.
- Мөн үйлдвэрийн хаалга, хашааны хаалга зэргийг засаж будсан, үйлдвэрийн дотор болон гаднах шаардлагатай газруудад тэмдэг, тэмдэглэгээ тавьж, ЦТП-г тусгаарласан 3 тал хашаа, хаалт хийж будсан. Хашаан доторх бохир тосны бошкуудыг суллаж зай, талбай гарган хураасан, үйлдвэрийн урт тениудын цуурч, цоорсон хэсгийг гагнаж засварласан зэрэг өвөлжилтийн бэлтгэл ажлуудыг хийсэн.

Үйлдвэрлэл, борлуулалтын тухайд:

Үйлдвэрт I улиралд багтаан богино хугацаанд тосоо сэлгэн халаах чадвартай уур үүсгэгч төхөөрөмж захиалгаар хийлгэж, явцын дундах засвар үйлчилгээ болон цэвэрлэгээг цаг тухайд нь хийсний үр дүнд тос боловсруулах тоног төхөөрөмжид ноцтой болон гэнэтийн гэмтэл зөрчил гараагүй жигд, хэвийн ажилласан. 2014 онд бид нийтдээ 687'484,35 л техникийн хаягдал тосыг гэрээт компаниудаас хуримтлуулан авч

өмнөх 2013 оны үлдэгдлийн хамт нийтдээ 1'245'646.35 литр түүхий эдийг цуглуулж авсан. Үүнээс 610'900 л мазут боловсруулан нэг литр тутмыг 655 – 773 ₮-ийн хооронд НӨАТ-гүй үнээр гэрээний дагуу борлуулснаар нийт 484'900'800 ₮-ийн орлогыг төвлөрүүлсэн байна.

2014 онд компанийн нийт борлуулалт өмнөх оноос 6.25 дахин өсч 722.6 сая төгрөгт, цэвэр ашиг/алдагдал өмнөх онд -793 сая төгрөг байснаас 299.1 сая төгрөгт хүрч үйл ажиллагаанд нөлөө үзүүлсэн.

Тосны үйлдвэрлэлийн түүхий эд болон боловсруулсан бүтээгдэхүүний нөөц 2014.12.31-ны өдөр дараах байдалтай байна.

Түүхий эдийн нөөц 404,317 литр  
Боловсруулсан тос /Мазут/ 67,947 литр

2015 оны борлуулалтын таамаглалын тухайд:

“Хай Би Ойл” ХК-ийн тос дахин боловсруулах үйлдвэр нь 2015 онд нийт 1'000 тонн буюу 1'000'000 литр мазутыг боловсруулж, түүнд хэрэглэгдэх түүхий эдийг тухай бүрт олж цуглуулахаар төлөвлөж байгаа.

2015 оноос бид мазутын 1 тонн тутмыг 2 янзын үнээр тооцож байхаар болж байна. Үүнд:

| № | Хугацаа /сараар/        | 1 тн мазутын үнэ /төгрөгөөр/ | Тайлбар       |
|---|-------------------------|------------------------------|---------------|
| 1 | 04 сараас 10 сар хүртэл | 900'000                      | эрэлтгэй      |
| 2 | 10 сараас 04 сар хүртэл | 800'000                      | эрэлт багатай |

Хөрөнгө оруулалт, хэрэгжүүлж буй төсөл:

“Хай Би Ойл” ХК Малайз улсад бүртгэлтэй өөрийн охин компани болох НВОil (L) Berhad компанийг БНАСАУ-ын нийслэл Пхеньян хотод нээсэн.

НВОil (L) Berhad компани нь БНАСАУ-ын үндэсний газрын тосны хайгуулын компани “Korea Oil Exploration Corp” компанитай хамтарсан төслийн нэг хэсэг болох БНАСАУ-ын эх газрын газрын тосны хайгуулын үйл ажиллагааг явуулах зорилготой юм.

Пхеньян хот дахь Янгадо зочид буудалд байрлах геологийн мэдээллийн төвийг байгуулсан ба шаардлагатай тоног техник хангамж болон программ хангамжийг суурилуулж улмаар БНАСАУ-д газрын тос байгалийн хийн чиглэлээр хийгдсэн бүх хайгуулын мэдээллүүд, геологи геофизикийн болон техникийн мэдээллүүдийг олж авч нэгтгэх, дахин боловсруулах, хөрвүүлэх ажлуудыг хийж байна.

Компани нь БНАСАУ-д стратегийн хөрөнгө оруулагчдыг урих, бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах зорилт тавин ажиллаж байна. Гэвч БНАСАУ нь эбола вирусаас шалтгаалан 2014 оны 10 сараас хойш хилээр шууд нэвтрүүлэхийг хориглосон болон хүйтний улирал давхцсан зэргээс шалтгаалан бидний ажил удаашрах нөхцөл үүссэн.

Түүнчлэн нефтийн үнийн бууралт нь тендерт оролцогчдын идэвхийг бууруулаад байгаа ба 2015 оны хагас жилээс зах зээлийн нөхцөл байдал сайжрах хандлагатай байгаа тул 2015 оны хоёрдугаар хагаст виртуал дата төвийг үүсгэж дуусах, олон улсын тендер зарлахын тулд олон улсын хуулийн зөвлөх, нефтийн маркетингийн компаниудыг урьж ажиллуулах төлөвлөгөөтэй байна.

**Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд:**

Компанийн 2013, 2014 оны жилийн орлогын тайлангийн үзүүлэлтээс зэрэгцүүлэн үзвэл:

| Үзүүлэлт                               | /сая төгрөгөөр/ |         |
|--|-----------------|---------|
|  | 2013 он         | 2014 он |
| Борлуулалт                             | 115,5           | 722,7   |
| Борлуулалтын хөнгөлөлт                 | -               | -       |
| Цэвэр борлуулалт                       | 115,5           | 722,7   |
| Борлуулсан бүтээгдэхүүний өртөг        | 94,6            | 469,5   |
| Нийт ашиг                              | 20,9            | 253,2   |
| Үйл ажиллагааны бусад орлого           |                 |         |
| Үйл ажиллагааны зардалд                | 1017            | 404     |
| Үйл ажиллагааны бус ашиг /алдагдал /   | 203,5           | 455,9   |
| Үйл ажиллагааны бус зардал             |                 |         |
| Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал / | (792,6)         | 305,1   |
| Орлогын татварын зардал                | 1,1             | 6,0     |
| Цэвэр ашиг /алдагдал /                 | (793,7)         | 299,1   |

Компани нь санхүүгийн тайлан балансыг хуульд заасан хугацаанд цаг тухайд нь гаргаж аж ахуй нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар, үл хөдлөх хөрөнгийн албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, газрын төлбөр, авто тээврийн өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр болон нийгмийн даатгалын тайланг хуульд заасан цаг хугацаанд нь өгч, албан татварыг бүрэн төлж байгаа.

2014 оны байдлаар 610.9 мянган литр мазут борлуулж 722,7 сая төгрөгийн орлого олж, борлуулсан бүтээгдэхүүний өртөг 469,5 сая төгрөг, үйл ажиллагааны зардалд 401,3 сая төгрөг, зээлийн хүүгийн зардалд 2,7 сая төгрөг, хүүгийн орлого 59,6 сая төгрөг, валютын ханшийн зөрүүний ашиг 396,3 сая төгрөг, орлогын албан татвар 6,0 сая төгрөг зардалтай нийт 299,1 сая төгрөгний ашигтай ажилласан байна.

Компани нь 2014 онд бүх татвар, нийгмийн даатгалын шимтгэлүүдийг цаг тухайд нь төлж байсан. Үүнд: НДШ -62,5 сая төгрөг, ААНОАТ-т 6,0 сая төгрөг, ХАОАТ-30,0 сая төгрөг, НӨАТ-т 35,3 сая төгрөг, газрын төлбөр 1,5 сая, үл хөдлөх хөрөнгийн албан татварт-6,2 сая төгрөг, Суутгагчийн хувь хүнд олгосон суутгасан албан татварт-0,2 сая төгрөг, АТӨЯХАТ-0,4 сая төгрөг, Газрын төлбөр-1,2 сая төгрөг, нийт 143,3 сая төгрөг төлсөн.

Компанийн 2013 он, 2014 оны хөрөнгө, эх үүсвэрийн тэнцлийн үзүүлэлтээс зэрэгцүүлэн үзвэл:

| Хөрөнгө, өр төлбөрийн үзүүлэлтүүд | сая /төгрөгөөр / |         |
|-----------------------------------|------------------|---------|
|                                   | 2013 он          | 2014 он |
| Эргэлтийн хөрөнгө                 | 3097,8           | 3183,8  |
| Эргэлтийн бус хөрөнгө             | 6389,8           | 6498,4  |
| Нийт хөрөнгийн дүн                | 9487,6           | 9682,2  |
| Богино хугацаат өр төлбөр         | 9160,9           | 9056,4  |
| Урт хугацаат өр төлбөр            |                  |         |
| Эзэмшигчийн өмчийн дүн            | 326,7            | 625,8   |
| Өр төлбөр, эзэмшигчийн өмчийн дүн | 9487,6           | 9682,2  |

Үнэт цаас гаргагчийн хяналтын багц эзэмшигчдийн мэдээлэл:

Хувьцааны 5 буюу түүнээс дээш хувийг эзэмшигч этгээд:

| №           | Хувьцаа эзэмшигчийн нэр           | Нийт хувьцааны хувь |
|-------------|-----------------------------------|---------------------|
| 1           | FIREBIRD GLOBAL MASTER HOLDINGS-2 | 28,29%              |
| 2           | БИДИСЕК ХК                        | 24,69%              |
| 3           | FIREBIRD MONGOL HOLDINGS A.S.A    | 16,76%              |
| 4           | ХҮДРЭЭ Ө.                         | 5,02%               |
| <b>Нийт</b> |                                   | <b>74,76%</b>       |

Үнэт цаас гаргагчийн ТҮЗ, дэд хороодын тайлан:

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр Б.Лхагвадорж, Ө.Хүдрээ, Б.Пүрэвбаатар, Кэйт Беннетт, Ж.Эрдэмбилэг, хараат бус гишүүдээр Х.Батхишиг, М.Батсүрэн, түр гишүүнээр Д.Даянбилгүүн, Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Б.Лхагвадорж, Гүйцэтгэх захирлаар Ө.Хүдрээ, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргаар Ж.Энхцэцэг нар ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал нар 100 хувь компанийн засаглалын сургалтанд хамрагдсан.

Үнэт цаас гаргагчийн удирдлага, эрх бүхий албан тушаалтны танилцуулга

| №  | Овог, нэр                          | Албан тушаал                                      | Боловсрол |
|----|------------------------------------|---|-----------|
| 1  | Бүрэнмэнд овогтой<br>Лхагвадорж    | ТУЗ-ийн дарга                                     | дээд      |
| 2  | Өлзийсайхан овогтой Хүдрээ         | Гүйцэтгэх захирал ТУЗ-ийн<br>ердийн гишүүн,       | дээд      |
| 3  | Баярсайхан овогтой<br>Пүрэвбатаар  | ТУЗ-ийн ердийн гишүүн, Санхүү<br>эрхэлсэн захирал | дээд      |
| 4  | Кэйт Беннетт                       | ТУЗ-ийн ердийн гишүүн                             | дээд      |
| 5  | Жүгдэрнамжил овогтой<br>Эрдэмбилэг | ТУЗ-ийн ердийн гишүүн                             | дээд      |
| 6  | Халтар овогтой Батхишиг            | ТУЗ-ийн хараат бус гишүүн                         | дээд      |
| 7  | Мажигсүрэн овогтой<br>Батсүрэн     | ТУЗ-ийн хараат бус гишүүн                         | дээд      |
| 8  | Сий Кок Хенг                       | ТУЗ-ийн хараат бус гишүүн                         | дээд      |
| 9  | Данзан овогтой Даянбилгүүн         | ТУЗ-ийн түр гишүүн                                | дээд      |
| 10 | Жаргал овогтой Энхцэцэг            | ТУЗ-ийн нарийн бичиг                              | дээд      |

“Хай Би Ойл” ХК 2014 оны 04 сарын 22-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулснаар дараах асуудлыг шийдвэрлэсэн.

1. Компанийн 2013 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн аудитын хорооны тайланг хэлэлцэн батлах
3. 2014 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах
4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
5. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын 2014 оны зардлын төсвийг батлах
6. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүдийг сонгосон бөгөөд 2014 оны 05 сарын 22-ны өдөр Төлөөлөн Удирдах зөвлөлийн хурлыг хуралдуулан ТУЗ-ийн дэргэдэх хороодыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсон.

А.Төлөөлөн удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудитын дэд хороог Х.Батхишиг, Б.Пүрэвбаатар, Сий Кок Хенг гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Аудитын хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Х.Батхишигийг томилсон.

Б. Төлөөлөн удирдах Зөвлөлийн дэргэдэх Цалин урамшууллын дэд хороог Ж.Эрдэмбилэг, Х.Батхишиг, М.Батсүрэн гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Цалин урамшууллын дэд хорооны даргаар ТУЗ-ийн гишүүн Ж.Эрдэмбилэгийг томилсон.

В. Төлөөлөн удирдах Зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх дэд хороог Ж.Эрдэмбилэг, М.Батсүрэн, Сий Кок Хенг гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Нэр дэвшүүлэх дэд хорооны даргаар ТУЗ-ийн гишүүн Ж.Эрдэмбилэгийг томилсон.